



Улс төрийн
Боловсролын
Академи



Монголын Нээлттэй
Нийгэм Хүрээлэн
(Соросын сан)

УЛСЫН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ

Иргэдэд зориулсан гарын авлага

Зохиогчид:

А.Пагма. УТБА-ийн багш-ЭША,
докторант
Г.Цог-Өрнөх УТБА-ийн багш-ЭША,
(PhD)

Зөвлөх:

Ж.Бямбадорж. УИХ-ын дэд дарга,
УТБА-ийн Удирдах зөвлөлийн
гишүүн. (PhD)

Улаанбаатар хот

УЛСЫН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ

1.	Улсын төсөв иргэн таньтай холбоотой юу ?.....	3-4
1.1	Юуны тулд Төрд мөнгө хэрэгтэй болдог вэ?.....	4-5
1.2	Төсөв санхүүгийн шинэ тогтолцооны эрх зүйн үндэс, зарчим.....	5-6
2.	Монгол Улсын нэгдсэн төсөв гэж юу вэ?.....	6
2.1	Улсын төсөв гэж юу вэ?.....	7
2.2	Монгол Улсын төсвийн орлого хэрхэн бүрддэг вэ?.....	7-11
2.3	Улсын төсвийг хэрхэн зарцуулдаг вэ?	11-13
2.4	Улсын төсвийн алдагдал гэж юу вэ?	13-15
3.	Төсвийн орчил гэж юуг хэлэх вэ?.....	15-16
3.1	Төсвийн төсөл боловсруулах, бэлтгэх үе шат гэж юу вэ?.....	16-18
3.2	Хэлэлцэн батлах үе шат гэж юу вэ?.....	18
3.3	Төсвийн хэрэгжилт ба гүйцэтгэлийн үе шат гэж юу вэ?.....	18-19
3.4	Улсын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн талаар иргэн Та юу мэдэхийг хүсч байна?.....	19-21
3.5	Төсвийн мөнгийг яаж зарцуулсныг хэрхэн хянадаг вэ?.....	21-24
4.	Иргэд бид улсын төсвийн үйл явцад хэрхэн оролцож болох вэ ?.....	24-27
4.1	Цаашид төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд юу хэрэгтэй байна вэ?.....	27-28

Ялгах тэмдэг:

4 - Хуулийн заалт

• - Хүснэгт, схем

? - Шог зураг

£ - Нэр томъёоны

тайлбар

ê - Жишээ

μ - Фото зураг

U - Зөвлөмж

Улсын төсөв иргэн таньтай холбоотой юу?



Улсын төсөв гэхлээр хүмүүс, бидэнд хамаагүй, биднээс тээр дээр оршдог, ойлгомжгүй, бидний “толгой хүрэхгүй” зүйл мэт хандаж, төсөвтэй холбоотой асуудлыг огт сонирхохгүй байх нь олонтаа. Гэтэл ардчилсан нийгэмд хүмүүс өөрсдийн хамтын амьдралыг зохион байгуулахын тулд бүрдүүлж байгаа мөнгийг улсын төсөв хэмээн хамгийн өргөн утгаар ойлгож болно.

Иймд энэхүү хөрөнгө мөнгө хэрхэн бүрддэг, хэрхэн захиран зарцуулдаг, гүйцэтгэлийг яаж хянаж шалгадаг талаар бүгд л их, бага ямар нэг хэмжээгээр мэдэх ёстой билээ.

Яагаад гэхээр, иргэн та бидний бүгдийн оролцоотой улсын төсөв бүрдэнэ. Энэхүү төсвийн хөрөнгөөр төр нь улсын хэмжээг бүхэлд хамарсан, олон мянган хүн ам, өрх гэр, орон нутаг, байгууллагыг нийтэд нь хэрхэн зохицуулах, улс орны хөгжлийг хэрхэн урагшлуулах, ирээдүйд иргэдийнхээ хангалуун амьдрах боломжийг яаж бий болгох зэрэг асуудлыг цогц байдлаар бодлогын түвшинд тодорхойлж үйл ажиллагаагаа явуулж байдаг.

Иргэн та бидний хувьд хэрэгцээ, хүсэл мөрөөдөл хязгааргүй. Харин боломж л хязгаарлагдмал байдаг. Хүн бүр аж ахуй эрхлэх, бизнес хийх, орлоготой, мөнгөтэй болох, боловсрол эзэмших, үр хүүхдээ сайн хүн болгон хүмүүжүүлэх, амьдрал ахуйгаа аятайхан аваад явах гэх мэтийн маш олон зорилго, санаа бодолтой байдаг. Үүнийг гүйцэлдүүлэх болоод ирэхээр бид мөнгө, туршлага, боловсрол, шинэ санаа дутагдах гээд олон хязгаарлах хүчин зүйлтэй тулгараад ирдэг.

Ê Жишээ нь, зарим нэг боломж надад байгаа гээд жижигхэн талхны үйлдвэртэй боллоо гэж үзье. Тэгтэл миний өмнө маш олон асуудал үүсээд ирнэ. Хаана үйлдвэрээ байгуулах, хэдэн хүн ажиллуулах, ямар тоног төхөөрөмжийг хаанаас хямдхан шиг олох, гурилаа хаанаас арай чанартайг нь бага үнээр олоод авах, хэдэн төгрөгөөр хаана зарах гээд. Мөн түүнчлэн газрын түрээсийн төлбөр, аж ахуй нэгжийн зөвшөөрөл, лиценз, татварын албаны бүртгэл, дүүргийн зөвшөөрөл зэрэг нь мөн л асуудал. Эцэст нь орлого олоод ирэхээр орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж гээд л үй түмэн асуудлыг шийдэж байж дараа нь тодорхой ашиг олж амьдрал ахуйгаа өөд нь татна. Ингэж нийгмийн баялгийг өсгөдөг. Тэгэхээр бүх зардлаа би талхандаа шингээж байж л ашиг олно. Өөрөөр хэлбэл, би хэрэглэгчдээс өртгөө авна гэсэн үг. Гүрийж байж олсон хэдийгээ бол маш үр өгөөжтэй зарцуулахыг хичээнэ.

Нөгөө талаас, “Төр орших үндсийн нэг нь татвар” гэж ярьдаг. Иргэн хүн хэн ч бай, аж ахуй эрхэлсэн, эрхлээгүй бүгд л татвар төлдөг. **Иргэнийхээ хувьд бид татвар төлөх үүрэгтэй.** Татвараар болон бусад төрлийн орлогоор төр нь санхүүжиж, тодорхой мөнгөн хуримтлалыг бүрдүүлэн түүнийг дахин хуваарилж боловсрол, эрүүл мэнд, дэг журам сахиулах, тэтгэвэр тэтгэмж гээд иргэддээ төрийн үйлчилгээг үзүүлдэг. Цаашлаад зам засах, гүүр үерийн далан барих, гудамж талбайг тохижуулах, харилцаа холбоо зэрэг томоохон объектод хөрөнгө оруулалт хийнэ. Ингэж нийтийн хэрэглээний баялгийг бий болгодог.

Өөрөөр хэлбэл, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлыг шийднэ. **Төрөөс үзүүлж буй үйлчилгээний өртөг нь иргэд та бидний татвараар төлж буй мөнгөний хэмжээнээс ихээхэн өндөр байдаг. Үүнийг иргэдийн зүгээс тэр бүр ойлгодоггүй, харин ч төрөөс аль болох ихийг шаардах, нэлээд үрэлгэн хэрэглэх сэтгэлгээ зонхилж байдаг нь түгээмэл ажиглагддаг.** Төрийн үйл ажиллагаа иргэдийн сайн сайхан байдалд чиглэгддэг ба энэ ажлыг төр нь зохицуулах үүргийг гүйцэтгэдэг. Дээрхи үйл ажиллагааг явуулахад хүн хүч, хөрөнгө мөнгө шаардлагатай бөгөөд түүндээ төвлөрүүлсэн төсвийн ихэнхи хэсгийг зарцуулдаг.

Иргэн та, бид татвараа зайлшгүй төлнө, энэ мөнгөөр төр үйл ажиллагаа явуулна, гэхдээ миний татварын мөнгө хэр зэрэг үр өгөөжтэй, хаана, юунд зарцуулагдаж байна вэ гэсэн асуудал зайлшгүй сонирхол татна. Нөгөө талаас, төрийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүс бидний татварын мөнгөөр цалинжиж байгаа болохоор бидэнд үйлчилгээ үзүүлэхдээ ямар нэг хүнд сурталгүй, соёлтой, зардал чирэгдэлгүй үйлчлэх ёстой гэсэн бодол төрнө.

Иймд иргэн та бид өөрийн мөнгөнөөс хэдийг, яаж, юунд, хэр үр дүнтэй зарцуулах тухай боддогийн нэг адилаар төрд өгсөн тэр мөнгөний талаар мөн л иймэрхүү асуулт тавин хандах нь ардчилсан нийгэм дэх хувь хүний нэг эрх байдаг. Энэ үүднээс төрийн үйлчлэх, зохицуулах үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа болон хэр үр өгөөжтэй зарцуулагдаж байгаа нь **иргэн бүрт нээлттэй, ил тод, хяналттай байх** нь чухал юм.

Иргэн та дээрхи хэсгийг уншаад төсөв гэх энэ мөнгийг юуны тулд бүрдүүлдэг, төсвийн төслийг хэрхэн боловсруулж, хэлэлцэн баталж, юунд хуваарилан зарцуулдаг бол гэсэн асуултыг бодож байгаа нь ойлгомжтой.

1.1

Юуны тулд Төрд мөнгө хэрэгтэй болдог вэ?



Нийтийн хэрэглээний барааг төр бий болгодог, тухайлбал, төрөөс шүүх, аюулгүй байдлыг хангах, засаг захиргаа, удирдлага, дэд бүтэц зэргийг санхүүжүүлэх, мөн боловсрол, эмнэлгийн хангамж үйлчилгээ гэх мэт нийгмийн чухал зорилтыг төр өөртөө авах, эсвэл үйлдвэрлэх боломжийг олгож, хянаж байх үүрэгтэй. Төр нь эдийн засаг, санхүүгийн бодлогоор дамжуулан үнийн түвшинг тогтворжуулах, ажил эрхлэлтийг аль болох өндөр түвшинд барьж, эдийн засгийн жигд өсөлтийг хангах ёстой болдог нь аль ч төрд түгээмэл байдлаар тогтсон байна.

Төрөөс иргэн хүн нэлээд олон төрлийн үйлчилгээг авах боломжтой, гэхдээ энэ бүх үйлчилгээг нэг дор авдаггүй. Харин зайлшгүй тохиолдолд төр иргэндээ ийм үйлчилгээг үзүүлэх шаардлагатай болдог. Тухайлбал, эрүүл мэнд, боловсрол, тэтгэвэр, тэтгэмж, халамж, зөвөлгөө, хамгаалал, даатгал гэх мэт.


**Төр нь
энэхүү
үйлчилгээг
үзүүлэхийн
зэрэгцээ
иргэн
Таны:**

- И** амь нас, эрх, эрх чөлөө, өмч хөрөнгийг хамгаалах
- И** шударга өрсөлдөөний орчинг баталгаажуулах
- И** хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх
- И** ажиллах, амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх
- И** нийгмийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй байна.

Иргэн танд болон бусдад үйлчилгээ үзүүлэх, үүргээ биелүүлэх, төрийн бодлого, үйл ажиллагааг амьдралд хэрэгжүүлэхийн тулд төрд тодорхой хөрөнгө, мөнгө, бүтэц, стратеги, төлөвлөгөө, зохион ба үйл шаардлагатай болно. Үүнийг хийж гүйцэтгэх үүргийг төрийн өмнөөс Засгийн газар хэрэгжүүлдэг.

1.2

Төсөв санхүүгийн шинэ тогтолцооны эрх зүйн үндэс



- И** Монгол Улсын Үндсэн хууль
- И** Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль
- И** Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль

4 “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хууль 2002 оны 06-р сарын 27-ны өдөр батлагдсан. Дагаж мөрдөх хугацаа 2003 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхэлсэн. Төсөв санхүүгийн шинэ тогтолцоо буюу “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хууль”-д улсын төсөв боловсруулах, хэлэлцэн батлах, гүйцэтгэл, хяналтын процесст тодорхой хугацаа, хүрээ хязгаар байхаар тогтсон.

*Улсын салбарын удирдлага,
санхүүжилтийн гарын
авлага, УБ., 2003.*

Төсөв санхүүгийн харилцааны шинэ тогтолцооны зарчим	и	Төсөв боловсруулах үйл явцыг стратегийн шинжтэй болгох
	и	Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн
	и	Хариуцлага ба тайлагналт
	и	Ил тод байдал, тайлан хэвлэн нийтлэгдэх
	и	Удирдлагын чадавхи
	и	Хяналт ба үнэлгээ
	и	Чадварлаг бүтэц


Өнөөдөр Монгол Улсад төсөв, санхүүгийн шинэ тогтолцоо бүрдээд хэрэгжиж байна. Энэ үйл явц бодитойгоор хэрэгжих нөхцөл боломж нь түүний эрх зүйн орчноор баталгаажиг байдаг. Төсвөөс санхүүжилт авч төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг нийт байгууллагын санхүүжилтийн болоод үйл ажиллагааны удирдлагын зарчмыг шинэчлэх зорилттойгоор, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

2. Монгол Улсын нэгдсэн төсөв гэж юу вэ?

Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг **Монгол Улсын нэгдсэн төсөв** гэнэ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, 3.1,2002.11.20


4



Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, 3.2.1,3.2.2


2.1

Улсын төсөв гэж юу вэ?



Улсын төсөв бол төрөөс төлөвлөгдсөн үйл ажиллагаагаа явуулах, чиг үүргээ хэрэгжүүлэх, иргэддээ үйлчилгээ үзүүлэх, орон нутгийн хөгжилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор татварын болон бусад хэлбэрээр бүрдүүлж байгаа мөнгөн хөрөнгө, үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөө юм. Төсвийг яаж бүрдүүлэх, хэрхэн зарцуулах вэ гэсэн орлого, зарлагын тооцоо ч гэж хэлж болно.

Улсын төсөв нь дараахь зүйлийн бүрдэл байна гэдгийг УИХ-аас хуульчлан баталдаг.



Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, 8.1,9.3,11.1,13.1

2.2

Монгол Улсын төсвийн орлого хэрхэн бүрддэг вэ?




Монгол улсын төсвийн орлогын үндсэн эх үүсвэр нь урсгал орлого юм. Энэ нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас улсын хууль тогтоомжийн дагуу татварын болон бусад хэлбэрээр татан төвлөрүүлдэг мөнгөн хөрөнгө байдаг. Түүнчлэн улсын төсөв нь хөрөнгийн болон тусламжийн орлогоос бүрдэнэ.

Төсвийн хөрөнгийн орлого нь өмч хувьчлалын орлого, төрийн өмчит ААН-ийн ноогдол ашиг, үндсэн хөрөнгө борлуулсны орлого, газар худалдсаны орлого, барааны нөөцийн борлуулалтаас ордог.

Төсвийн тусламжийн орлого нь Олон улсын байгууллага ба гадаад орны урсгал болон хөрөнгийн тусламж, Засгийн газар ба нутгийн захиргаадын хоорондын тусламжаас бүрдэнэ.

Урсгал орлого нь татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

ê **Тухайлбал, Монгол Улсын 2004 оны төсвийн орлогын төлөвлөгөө:**



*Төрийн мэдээлэл,
2003.12.10, №46/331/*

Татварын болон татварын бус доорхи хэлбэрээр авсан мөнгө нь төсвийн орлогын дийлэнхи хэсэг болдог. Үүнийг **улсын төсвийн урсгал орлого гэнэ**.

Улсын төсвийн урсгал орлого

Татварын орлого:

- 8 Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар
- 8 Нэмэгдсэн өртгийн албан татвар
- 8 Онцгой албан татвар
- 8 Гаалийн албан татвар
- 8 Автобензин, дизелийн түлшний албан татвар
- 8 Ашигт малтмал/алт/-ын нөөц ашигласны төлбөр
- 8 Ашигт малтмал хайгуулын болон ашигт малтмал ашиглах лицензийн төлбөр
- 8 Хүн амын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар

Татварын бус орлого:

- 8 Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчинд ногдох хувьцааны ногдол ашиг
- 8 Төрийн өмчийн эд хөрөнгө ашигласны төлбөр болон борлуулсны орлого
- 8 Хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт орох бусад орлого

*Монгол Улсын нэгдсэн
төсвийн тухай хууль, 9.1, 9.2*



Иргэн та бидний татварын болон бусад хэлбэрээр, янз бүрийн хувь хэмжээтэй төлсөн мөнгө төсвийн орлого бүрдэх үндсэн эх үүсвэр болдог тухай дээр өгүүлсэн. Улсын төсвийн орлогод орох татварын хувь хэмжээг хуульчлан тогтоож өгдөг. Манай оронд энэ нь харилцан адилгүй байдаг ба татварын хуулиар зохицуулдаг.

Монгол улсын татварын тогтолцоо албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ.

МУ-ын татварын ерөнхий хууль. 3-р зүйл 1,2,3

Иргэн Та одоогийн хэрэгжиж буй хууль тогтоомжийн дагуу ямар татвар, төлбөр, хураамжийг төлж байна вэ?

Орлогын албан татвар:

- Аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар
- Хүн амын орлогын албан татвар

ê **Тухайлбал:**

✓ Албан татвар ногдох жилийн орлого нь 100.0 сая төгрөг хүртэлх татвар төлөгч 15%-иар, түүнээс дээш төгрөгний албан татвар ногдуулах жилийн орлогод 15.0 мянган төгрөг дээр 100.0 сая төгрөгнөөс дээш орлогын дүнгийн 30%-иар нэмж албан татвар ногдуулна. Хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлогод 15%-иар бодож ногдуулна.

✓ Малын татвар нь өөрийн эзэмшлийн малаа хонин толгойд шилжүүлсэн байдлаар малын тоо толгойд ногдуулсан өмчийн татвар юм. Үүнд, тэмээ, адуу, үхэр тус бүр 5, ямаа 1.5, хонь 1 хонин толгой гэх байдлаар тооцно.

Хөрөнгийн албан татвар:

Хөрөнгийн буюу өмчийн татварт үл хөдлөх хөрөнгө борлуулсны, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, бууны албан татварыг хамруулна.

ê **Тухайлбал:**

✓ Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 0.6%-иар тооцож байна .

Хэрэглээний татвар:

- нэмэгдсэн өртгийн албан татвар,
- онцгой албан татвар,
- гаалийн албан татвар,
- авто бензин, дизелийн түлшний албан татвар

ê **Тухайлбал:**

Нэмэгдсэн өртгийн албан татварыг импортлосон болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний татвар тооцох үнэлгээнээс 15%-иар бодож ногдуулна.


**Бусад татвар,
төлбөр, хураамж**

Хэрэглэгчид төрөөс нийтийн зориулалттай бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээг хэрэглэх, эсвэл худалдан авах, түрээслэхэд тодорхой хэмжээний хураамж, төлбөрийг төлдөг

ê **Тухайлбал :**

- ✓ Улсын тэмдэгтийн хураамж нь шүүхийн, паспорт, виз, аж ахуйн нэгж бүртгүүлэх, үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх гэх мэт.
- ✓ Рашаан ашигласны төлбөр нь эмчилгээний зориулалтаар ашиглахад 1 куб метр рашаанаас 10-50 төгрөг байна.
- ✓ Ус ашигласны төлбөр нь нийтийн ундны усны эдийн засгийн ашиглалт 1-10 төгрөг, аж ахуйн нэгж байгууллага 1-20 төгрөг төлнө.

ê **Жишээ нь,** 2004 оны улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөөний бүтэц



Практик амьдрал дээр хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагын хувьд орлогын, ашгийн, өмчийн татвар гэж байдаг бол, жирийн иргэдийн хувьд өөрсдийн хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг худалдан авч буй байдлаар татвар төлдөг. Энгийнээр хэлбэл, энэ нь хэрэглэгчийн худалдан авсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд шингэсэн татвар хэлбэртэй байдаг. Энэ утгаараа хүн бүхэн, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж бүр татвар төлөх нь зайлшгүй бөгөөд энэ нь улсын төсвийн бүрдлийн чухал хэсэг болдог.

2.3

Улсын төсвийг хэрхэн зарцуулдаг вэ?



Иргэн танаас татварын болон бусад хэлбэрээр албадлагын шинжтэй авч төвлөрүүлсэн мөнгөн хуримтлал болох төсвийг аль ч төр хамгийн үр өгөөжтөйд нь зарцуулахаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

Мэдээж иргэн та бидний хувьд үнэнч шударгаар төлсөн мөнгөө хэрхэн зарцуулахыг сонирхохгүй байх нь юу л бол. Бид бол өөрт орох орлогоос илүү зүйлийг зарцуулж чадахгүй. Харин төр нь татвараа өсгөх замаар өөрийн орлогыг нэмэгдүүлж болдог, монополь эрхтэйгээрээ ялгагдана.

Төсвийн зарлага нь нийгмийн үйлдвэрлэлийг өргөтгөх, соёл, олон нийтийн арга хэмжээг санхүүжүүлэх, шинжлэх ухаан, техник, технологийг хөгжүүлэхэд зориулсан улсын төсвийн орлогыг дахин хуваарилах явцад үүсч буй харилцаа юм.

Төсвийн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд батлагдсан төсвөөс төсвийн захирагчийн үйл ажиллагаа, түүний үр дүнг санхүүжүүлэхээр хуваарилж, зарцуулж буй төсвийн хөрөнгийг **төсвийн зарлага** гэдэг.

2002 оны 11-р сард батлагдсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай” хуулийн 12.2 дугаар зүйлд төсвийн зарлагыг үндсэн 4 төрлийн ангиллаар мөрдөхөөр заасан.

Төсвийн зарлагын өдөр тутмын хэрэглээнд, өөрөөр хэлбэл дахин ашиглагдахгүй нэг удаа зарцуулаад өнгөрөх буюу хамгийн идэвхгүй зардлуудыг **урсгал зардал** гэнэ. Төсвийн урсгал зардлыг бууруулснаар зарлагын идэвхтэй хэсэг буюу нийгмийн цаашдын хөгжлийг тодорхойлогч хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэх боломж бүрддэг.

Өнөөдөр Монгол улсын хэмжээнд төсвийн хэлбэрээр улсын 389, орон нутгийн 3742, нийтдээ 4131 төсвийн байгууллага байгаа бөгөөд энд нийтдээ 117797 хүн ажиллаж, төсвийн мөнгөөр цалинжиж, иргэдэд үйлчлэх үйл ажиллагаа явуулж байна.

*Төсвийн байгууллагын удирдлага,
санхүүжилтийн шинэчлэл. Онол, практик,
хэрэгжилт. 102, 107 х. УБ., 2003*

Улсын төсвийн зарлагын ангилалтай уялдуулан төсвийн зарлагын дэлгэрэнгүй ангиллыг Засгийн газар тогтоож баталдаг. Тухайлбал, төсвийн урсгал зардлын болон төсвийн хөрөнгийн зардлын анги гэж ангилна.

Улсын төсвийн зарлагын ангилал

**Бүтээгдэхүүний
ангиар хуваарилсан
төсөв**

Засгийн газар төсвийн байгууллага, бусад этгээдээс бүтээгдэхүүн худалдаж авах зардал юм.

ê **Тухайлбал**, эмнэлгийн тусламж, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийг хянах, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, ерөнхий дунд боловсролд олгох үйлчилгээ, галт түймрээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ, цагдаагийн үйлчилгээ, зам засварын үйлчилгээ гэх мэт.

**Улсын
төсвөөс төлөх
тэтгэвэр, тэтгэмж,
бусад зардал**

Ямар нэгэн бараа үйлчилгээ хариуд нь авалгүйгээр Улсын төсвөөс төлөх бусад шилжүүлж буй мөнгөн хөрөнгө, зардал юм.

ê **Тухайлбал**, ажилгүйдлийн тэтгэмж, өндөр насны тэтгэвэр, төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөр гэх мэт.

**Өмчлөгчийн
эрхийг хэрэгжүүлэхтэй
холбогдсон бусад
зардал**

Төсвийн байгууллагын өмчлөлийн хувьд Засгийн газраас гарах урсгал зардал.

ê **Тухайлбал**, төрийн албан хаагчдын давтан сургалтын зардал, бүтцийн өөрчлөлтийн зардал, хөрөнгийн дахин үнэлгээний зардал, урсгал засварын зардал гэх мэт. Төсвийн байгууллагын өмчлөлийн хувьд Засгийн газраас гарах урсгал зардал.


**Хөрөнгө
оруулалтын
зардал**

Улсын төсвөөс санхүүжүүлэх улсын өмчид оруулах хөрөнгө оруулалтын зардал.

ê **Тухайлбал**, улсын болон орон нутгийн чанартай зам барих, цахилгаан станц, нисэх буудал, цахилгаан дамжуулах шугам гэх мэт төрийн өмчийн объектыг барьж байгуулах зардал. Мөн хөрөнгө оруулалтын зардалд төсвийн байгууллагуудад оруулах хөрөнгө оруулалтын зардал орно.

ê **Тухайлбал**, барилгын өргөтгөл, их засвар хийх, компьютер тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, программ хангамж худалдан авах гэх мэт.

ê **Жишээ нь**, 2004 оны Улсын төсвийн зарлагыг доорх бүтцээр харуулав.



Улсын төсвийн зардалд урсгал зардал дийлэнхи хувийг эзэлдэг. Өөрөөр хэлбэл, хэрэглээний зардал бараг тэн хагасыг эзэлж байна. Энэ нь эргэж төлөгдөх боломжгүй буюу идэвхигүй зардал юм. Бидний бодлоор мөнгийг хамгийн үр ашигтайд нь зарцуулах ёстой. Бидний ярьдгаар эргээд өгөөжөө өгөх зүйлд л анхаарах хэрэгтэй.

Иргэн та бид төрөөс улс орноо хөгжүүлэх, иргэдэд үйлчлэх үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан татан төвлөрүүлж буй татварын орлогын бүрдэл хэсгүүд, нөгөө талаас, нийгмийн баялгийг бий болгох, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах зэрэгт ямар үйл ажиллагаа явуулах, хөрөнгийг хэрхэн хуваарилах, зарцуулах зарлагын бүрдэл хэсгүүдийн талаар тодорхой ойлголттой боллоо.

2.4

Улсын төсвийн алдагдал гэж юу вэ?

Бид өөрсдийн санхүүгийнхээ ашиг, алдагдлыг орлогоосоо зардлаа хасаад амархаан тооцож байдагтай адилаар улсын төсвийн алдагдлыг бас тооцож болно. Энэ нь улс орнуудад байдаг л үзэгдэл. Гэхдээ хэрээс хэтэрвэл аюултай. Хэвийн төсөв гэж байна, энэ нь улсын төсвийн зарлага орлоготойгоо тэнцүү байхыг хэлнэ.

Улсын төсвийн алдагдал нь улс орон бүрт байдаг түгээмэл ойлголт юм. Алдагдлын шалтгаан янз бүр байж болно. Ерөнхийдөө алдагдлын шалтгаан нь татварыг нэмэгдүүлэх сонирхол, боломж бага байхын зэрэгцээ Засгийн газар татвар бага аваад санхүүжилт хийх хэрэгцээ их байдагтай холбоотой. Төсвийн алдагдлыг нэлээд хэдэн хэлбэрээр ангилдаг байна. Үүнд: урсгал тооцооноос гарах алдагдал, гадаад хүчин зүйлийн алдагдал, урсгал зарлагын өсөлтийн алдагдал, мөнгө зээлийн бодлогын алдагдал, субъектив хүчин зүйлийн алдагдал, хөрөнгө оруулалтын бодлогын алдагдал, урсгал орлогын алдагдал, санхүүгийн буруу бодлогын алдагдал зэрэг орно¹.

¹ Г.Энхбаяр, Л. Отгонтуяа Төрийн санхүүгийн удирдлага, УБ., 2003, 251-253х.

Засгийн газрын хувьд төсвийн алдагдлын эдгээр хэлбэрийг маш нарийн судалж, анхаарлаа төвлөрүүлж ажилладаг. Төсвийн хөрөнгийг үйлдвэрлэл үйлчилгээг бий болгох, дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэгт чиглүүлэн ашиглаж, алдагдлаа өсгөж байвал энэ нь улс оронд нэг их аюултай биш. Өөрөөр хэлбэл, ирээдүйд хөрөнгө оруулалт нэмэгдэх, ажлын байр бий болох, үйлдвэрлэл идэвхижих, иргэд орлоготой болох нөхцөл бүрдэж байна гэсэн үг юм. Энэ утгаараа улсын төсвийн зарцуулалт хэрэглээнд голлон чиглэгдэх бус хөрөнгө оруулалтанд анхаарах нь чухал гэж үздэг. Харин улсын төсвийн мөнгийг цалин хангамжаа нэмэгдүүлэх, захиргааны бүтэц, зардлаа ихэсгэх зэрэг өөрөөр хэлбэл, мөнгийг хэрэглээ талд нь хэтэрхий их хэмжээгээр зарцуулж алдагдал өсөж байвал мэдээж энэ нь зохимжтой бус гэдэг нь ойлгомжтой.



Төсвийн алдагдал олон жил дамжин хуримтлагдсанаар нэг талаас, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх идэвхи буурах, ажилгүйдэл өсөх, хүн амын бодит орлого буурах, инфляци өсөх, мөнгөний үнэ ханш буурах, зээлийн хүү өсөх нөгөө талаас, гадаадын хөрөнгө оруулалт буурах, улсын өр нэмэгдэх зэрэг олон талын сөрөг үр дагавартай байдаг. Иймд, төрийн зүгээс төсвийн алдагдлыг багасгах олон талын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай болно. Төрөөс татварын оновчтой бодлого явуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих, төсөв санхүүгийн шинэ бодлого ба мөнгө зээлийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх гэх мэт олон үйл ажиллагааг явуулдаг. Манай орны хувьд л гэхэд 2003 оноос эхлэн хэрэгжүүлсэн “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль” нь дээрхи арга хэмжээний нэг гэж хэлж болох юм.

Төсвийн байгууллагын үйл ажиллагаа аль болох бага зардалтай, хүнд сурталгүй иргэдийн сэтгэл ханамжинд чиглэсэн байх, чадварлаг бүтэцтэй, төсвийн зарлага нь хэрэглээнд бус хөрөнгө оруулалтанд зарцуулагдах, энэ нь иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэгдэж байх нь нэн чухал юм. Төсвийн мөнгийг төр өөрөө бий болгодоггүй, энэ нь иргэдийн зүгээс төлж буй татварын мөнгө байдагт гол учир оршино. Мөн иргэдийн хувьд ч өөрсдөө энэ талаархи мэдээллийг холбогдох байгууллага, хүмүүсээс олж мэдэхийг шаардах эрхтэй.

3.


Төсвийн орчил гэж юуг хэлэх вэ?



Улсын төсөв нэлээд ярвигтай асуудал. Нэг талаас их хэмжээний мөнгө иргэдийн татвар болон бусад хэлбэрээр орж ирдэг, түүнийг яаж, ямар хэлбэрээр авах, хэдий хэмжээтэй тогтоох вэ, нөгөө талаас, хэрхэн юунд хуваарилан зарцуулах, тэр нь ямар бодит үр дүнд хүрэх вэ гэсэн уялдаа холбоо бүхий асуудал гардаг. Энэ асуудлыг тодорхой үе шаттайгаар авч үздэг, үүнийг төсвийн орчил гэнэ.

Тодруулж хэлбэл, улсын төсвийн төслийг бодит байдалд тулгуурлан боловсруулж бэлтгэх, юуг түүндээ тусгах вэ гэх зэрэг асуудлаас эхлээд хаана, хэзээ, юуг хүргүүлэх, түүнийг хэн хүлээж авах, хэлэлцэн батлах, хэн яаж хэрэгжүүлэх, гүйцэтгэх, цаашлаад хэн ямар хяналт тавих, үнэлэх гэх мэт нарийн уялдаа холбоо, дэс дараалал бүхий үйл ажиллагааны тухай асуудал байдаг.


Төсвийн орчил гэдэг нь тогтсон үйл явдал буюу арга хэмжээ тодорхой дэс дараалалтайгаар дахин давтагдах үйл явц, өөрөөр хэлбэл, төсөв зохиох болон төсөв зарцуулах явцад дахин давтагдах үйл ажиллагаа юм.



Иргэн та өөрийн аж ахуйн төсөв санхүүгийн асуудлыг шийдэхэд хэнээс ч хамааралгүйгээр өөрөө шийдчихдэг. Мөн хэдэн төгрөгийг татварын ямар хэлбэрээр өгч байгаагаа ч мэддэг. Тэгвэл улсын төсөв санхүүгийн асуудал бол улсын хэмжээний, өөрөөр хэлбэл маш олон иргэд, өрх гэр, аж ахуйн нэгжийг бүхэлд нь хамарсан асуудал, тэр тусмаа улс орны нийгмийн болоод эдийн засгийн хөгжлийн асуудал яригдаж байгаа болохоор төвөгтэй санагдаж магадгүй. Гэхдээ өөрийн өгсөн мөнгөний тухай яригдаж байгаа болохоор ямар нэг байдлаар төсвийн орчлын тодорхой үе шатуудыг ямар нэг эх үүсвэрээс мэддэг, хянадаг байх нь зүй ёсны хэрэг юм. Одоо энэ үе шатуудын тухай товч өгүүлье.

3.1

Төсвийн төсөл боловсруулах, бэлтгэх үе шат гэж юу вэ?



1. “Төсвийн хүрээний мэдэгдэл” гэж дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийг зохиоход Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлж УИХ-аас зөвшөөрсөн баримт бичгийг хэлнэ. Үүнд дараахь зүйлийг тусгасан байна.

- Ø Засгийн газраас тухайн жилд төлөвлөсөн төсвийн урсгал зардал болон орлогын хэмжээ, хөрөнгө оруулалт, нийт болон урсгал тэнцэл, төлөвлөсөн баланс, мөнгөн гүйлгээ, тэдгээрийн талаар дараагийн хоёр жилд тавих зорилт,
- Ø Макро эдийн засгийн болон дээрхи заалтын үзүүлэлтүүдийн тооцоо, танилцуулга,
- Ø Эдгээр нь төсвийн удирдлагын зарчимд хэрхэн нийцэж байгаа талаарх дүгнэлт.

*ТБУСТ хуулийн 4.1.6,
25.2.1-25.2.4*

2. “Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө” нь тухайн байгууллагын төсөв боловсруулах үндэслэл болно. Энэ төлөвлөгөөнд ирэх гурван жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараахь зүйлийг тусгана. Үүнд:

- Ø Байгууллагын гурван жилийн хэтийн зорилтууд,
- Ø Дараагийн жилд нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, тоо хэмжээ, өртөг,
- Ø Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй ижил үзүүлэлтээр боловсруулсан байгууллагын төсөв,
- Ø Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад асуудал.

*ТБУСТ хуулийн 26.1-
26.2.4*

3. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл” нь улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтын саналыг үндэслэсэн байна. Үүнд дараахь шаардлагыг хангасан байна.

- Ø Улсын төсвийн төсөлтэй уялдсан байх,
- Ø Засгийн газрын богино ба дунд хугацааны хэтийн зорилтуудыг тусгах,
- Ø Хуваарилагдсан төсвийг захиран зарцуулах этгээдийг заах,
- Ø Эрхлэх асуудлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бүтээгдэхүүнийг анги тус бүрээр тодорхойлж, нийлүүлэх байгууллага, худалдан авахад гарах зардлыг заах гэх мэт.

*ТБУСТ хуулийн 29.1,
30.1-30.1.11*

4. “Улсын төсвийн баримт бичиг”-т:

- Ø Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл,
- Ø Улсын төсвийн төсөл, түүний тухай илтгэл,
- Ø ТЕЗ бүрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн төсөл,
- Ø Түүнчлэн 32.2-32.2.4

*ТБУСТ хуулийн 32.1.1-
32.1.3*

3.2

Хэлэлцэн батлах үе шат гэж юу вэ?



Засгийн газрын өргөн мэдүүлсэн Улсын төсвийн төслийг УИХ-аар хэрхэн хэлэлцэж, батлах дараалал, журмыг **УИХ-ын Дэгийн тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 33-р зүйлээр тогтоосон** бөгөөд 4 үе шатаар хэлэлцэн жил бүрийн 12-р сарын 1-ний дотор Улсын төсвийг баталж, хууль гаргана.

Ø 1-р хэлэлцүүлэг: УИХ, Засгийн газрын өргөн мэдүүлсэн Улсын төсвийн тухай хуулийн төслийг нэгдсэн чуулганаар авч хэлэлцээд дэмжвэл байнгын хороодод шилжүүлнэ.

Ø 2-р хэлэлцүүлэг: Байнгын хороод тус бүртээ хэлэлцэнэ. Ийнхүү хэлэлцэх явцад иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг УИХ-ын гишүүд гаргадаг. Байнгын хороод саналаа гарган Нэгдсэн чуулганаар хэлэлцүүлнэ. Санал хурааж шийднэ.

Ø 3-р хэлэлцүүлэг: Дэмжигдсэн саналуудыг Төсвийн төсөлд тусган УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэнэ.

Ø 4-р хэлэлцүүлэг: УИХ, Улсын төсвийн тухай хуулийг зүйл, заалт бүрээр нь хэлэлцэн батална.

3.3

Төсвийн хэрэгжилт ба гүйцэтгэлийн үе шат гэж юу вэ?

Ø Төсвийн гүйцэтгэл гэдэг нь урьдаас төлөвлөгдөж батлагдсан орлогыг заасан хэмжээгээр зохих хугацаанд нь дайчлан оруулах, төсөвлөгдсөн зардлыг зохих ёсоор зарцуулах үйл ажиллагаа юм.

Ø Төсвийн гүйцэтгэлийг хангах ажиллагааг тус улсын төрийн эрх барих байгууллагын шууд удирдлага дор төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд гардан хэрэгжүүлнэ.

Ø Гүйцэтгэлийн үе шат нь төсвийн хөрөнгийг ашиглахаас эхлээд тайлан гаргах үе шат юм.

Иргэн та хуульчлан батлагдсан зүйлийг зарцуулах ёстойд нь л зарцуулах байх гэж бодож байгаа. Гэтэл төсвийн хөрөнгийг бүтцээ томруулан хэт олон орон тоо бий болгон хүнд суртлыг нэмэгдүүлэх, үр ашиггүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн зарцуулах зэрэгт түлхүү хэрэглээд байвал төсвийн алдагдал өснө, улсын өр мөн адил өснө, цаашлаад яваандаа төр засаг түүнийгээ даахгүй хүнд хэцүү байдалд орно. Ийм учраас иргэн таны

хяналт, цаашлаад төсвийн зарцуулалтын талаархи үнэн бодит мэдээлэл, төсвийн бодлого хэрэгжилтэнд иргэдийн оролцоо зайлшгүй чухал, нөгөөтэйгүүр, төрд түүний үйл ажиллагаа болон санхүүгийн ба бусад ажлыг хянаж, хариуцлага тооцож байдаг хөндлөнгийн байгууллага чухал хэрэгтэй.

Ийм байдал үүсгэхгүйн тулд улсын төсвийг бидний өөрсдийгөө төлөөлүүлэн, эрх ашиг, хүсэл сонирхлоо төрийн бодлогын хэмжээнд илэрхийлэх үүрэг хүлээлгэн сонгосон УИХ-аар хэлэлцэн баталж хуульчилдаг. Өөрөөр хэлбэл, төсвийг яаж бүрдүүлэх, юунд зарах, ямар үр дүнд хүрэх, цаашлаад төсөв алдагдалтай байх, хойч үе, үр хүүхдэдээ өр үлдээх эсэх асуудал тэнд л шийдвэрлэгддэг байна.

3.4

Улсын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн талаар иргэн Та юу мэдэхийг хүсч байна?



Ø Төсвийн гүйцэтгэлийн үе шат нь тайлан гаргах үйл явцаар дуусна.

Ø Тайлангийн гол зорилго нь төсөв хэрэгжүүлэх зарчим зөрчигдөөгүйг баталгаажуулах явдал юм.

Ø Түүнээс гадна тайлангийн хэлбэр, цар хүрээ нь олон нийтийн хяналт тавих боломжийг хангасан байх ёстой гэдгийг **Та анхаараарай.**

4 Төсвийн захирагчид төсвийн үр дүнг санхүүгийн ба санхүүгийн бус тайлангийн хэлбэрээр гаргана.

Ø **Төсвийн байгууллагын түвшинд:** сар бүрийн төсвийн санхүүжилтийг тайлагнах сарын тайлан мэдээ, улирлын санхүүгийн тайлан, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн улирлын тайлан, жилийн бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг харуулах жилийн тайланг гаргана.

Ø **Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд:** улсын болон орон нутгийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн тайлан, жилийн тайланг дараа жилийн 2 дугаар сарын 20-ны дотор гаргана.

Ø **Засгийн газрын түвшинд:** СЭЗЯ улсын төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 3 дугаар сарын 20-ны дотор гаргана.

Ø **Засгийн газар нэгдсэн төсвийн гүйцэтгэл** ба Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайландаа төрийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулан УИХ-ын дараа оны хаврын чуулганд оруулж, батлуулна.

Иргэн Та Улсын төсвийн мөнгө, хөрөнгө хэрхэн зарцуулагдсан талаархи тайланг үзэхийг хүсвэл дараахь байгууллагуудад хандах буюу дараахь сэтгүүл, товхимолыг үзэж болно.



- Ø Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар. Хаяг: Нэгдсэн үндэсний гудамж 5/1, Засгийн газрын 2 дугаар байр. Утас: 329356, 329051, 319136
- Ø Үндэсний Аудитын газар. Хаяг: Засгийн газрын 4 дүгээр байр, 311 тоот. Утас: 310555



- Ø “Төрийн мэдээлэл” сэтгүүлийг УИХ-ын Тамгын газраас эрхлэн долоо хоног тутам гаргадаг бөгөөд УИХ-ын албан мэдээ, баталсан хууль, тогтоол болон Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол зэрэг албан ёсны баримт бичгүүд хэвлэгддэг.
- Ø Монгол улсын Засгийн газраас жил бүрийн улсын төсвийн гүйцэтгэлийн тайланг тусгайлан хэвлэн гаргаж нийтийн хүртээл болгож байна.
- Ø Мөн төсөвтэй холбоотой төрөл бүрийн мэдээллийг Нээлттэй Нийгэм Форумын www.forum.mn хаягаар интернэтээс авч болно.

**Ил мэдээлэл иргэнийг хүчтэй болгоно
Иргэн хүчирхэг бол төр хүчирхэг !**



Ø “Санхүү, эдийн засгийн мэдээлэл” сэтгүүлийг Монгол улсын Санхүү, эдийн засгийн яамнаас эрхлэн улирал тутам гаргадаг байна. Уг сэтгүүлд мөн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан болон эдийн засгийн чухал асуудлаар материал хэвлэгддэг юм.

3.5

**Төсвийн мөнгийг
яаж зарцуулсныг
хэрхэн хянадаг вэ?**



**Бусдын мөнгийг
захирахад хяналт
зайлшгүй
шаардлагатай**

Төсвийн хяналтыг ямар зорилгоор хийдэг вэ?

- ∅ Төсвийн хөрөнгийг төсөвлөгдсөн нийтийн зорилгод ашиглаж байна уу? Төсвийн орлого, зарлагад хүчин төгөлдөр хууль тогтоомжийг мөрдөж байна уу? гэдгийг тодруулах ,
- ∅ Төсвийн хөрөнгийг зориулалтаар нь, аж ахуйчаар, хэмнэлттэй зарцуулж байна уу? Төр төсвийн хөрөнгөөр хүрэх гэсэн зорилгодоо хүрч, төрийн үйлчилгээг иргэддээ бүрэн хүргэсэн үү? гэдгийг ч бас тодруулах зорилгоор хийгддэг¹.

¹ Монгол, Герман улсуудын санхүүгийн хууль, хяналт. УБ., 1999 он, 141 дэх тал

Санхүүгийн хяналт шалгалтын үндсэн зарчмууд

- ∅ Шалгуулж буй байгууллагаас хараат бус, гадны нөлөөнд үл автах нөхцөлд ажиллах
- ∅ Зөвхөн хуульд захирагдана
- ∅ Шалгалтанд өртөхгүй байгууллага байхгүй
- ∅ Бодитой байх
- ∅ Шалгалтын тайланг Улсын Их Хуралд болон олон нийтэд тайлагнах
- ∅ Тайлан нийтэд ойлгомжтой хэлбэрээр, ойлгомжтой хэлээр бичигдсэн байх ёстой

Нэгэнт хяналт шалгалт зайлшгүй юм бол түүнийг хэрэгжүүлэх байгууллага хэрэгтэй.



m Гадны эрх бүхий байгууллагаас хийх шалгалт

m Хяналтын дээд байгууллага болох Үндэсний Аудитын Газар

m Албан газар, байгууллага, удирдлагын тухайн түвшин өөрийн үйл ажиллагаандаа хийх санхүүгийн шалгалт

m Мэргэжлийн хяналтын газар дахь санхүүгийн хяналт шалгалтын алба



Үндэсний Аудитын газар нь Улсын Их Хурлын хүсэлтээр төсвийн салбарын аль ч байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж болно.

Иймд иргэн Та өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнээр дамжуулан саналаа гаргаж болно.

- Ø Үндэсний Аудитын Газар нь улсын төсвийн мөнгийг зориулалтаар нь зарсан эсэхийг шалгадаг төрийн хяналтын төв байгууллага болно.
- Ø Үндэсний Аудитын Газар нь улс төрчид болон албан тушаалтнуудаас хараат бус байж шалгалтынхаа дүнг УИХ-д шууд тайлагнаж, аудитын дүгнэлтийн үнэн зөв байдлыг УИХ-ын өмнө хариуцдаг.

Иргэн Та төсвөөс санхүүждэг ямар ч байгууллагын санхүүгийн тайланд ҮАГ-ын хийсэн шалгалтын дүн, тайлан материалтай ҮАГ-ын хуулийн зөвлөхтэй уулзан, эндээс үзэж танилцах бүрэн бололцоотой. Хаяг:

Засгийн газрын 4 дүгээр байр, 311 тоот. Утас: 310555

Үндэсний аудитын газар хүсэлт ирүүлсэн хүмүүст төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг хэвлэмэл эхээр нь буюу хувилж өгч болно.

“Төрийн Аудитын тухай” Монгол улсын хууль. 5 дугаар бүлэг, 25 дугаар зүйл

Төсвийн гадаад хяналтын нэг гол субъект нь парламентын гишүүнээ сонгож, татвараар төрөө санхүүжүүлдэг иргэн хүн байх ёстой. Татвар төлөгч жирийн иргэн хүн бүр төсвийн үрэлгэн зарцуулалт, төрийн албан хаагчдын авилгалд өртөх боломжийг хаах талаар санаа тавьдаг, сонирхдог, энэ чиглэлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх хэрэгтэй.



“Итгэ! Тэхдээ шалга! Итгэх нь сайн, хянаж шалгах нь бүр ч сайн” гэсэн үг байдаг. Энэ бүхнээс төр засагт хяналт шалгалт шаардлагатай гэсэн дүгнэлт гарна.

4.

Иргэд бид улсын төсвийн үйл явцад хэрхэн оролцож болох вэ?

“Би огт оролцохгүй байснаас харин таагүй байдалд хүрсэн ч гэсэн эрх чөлөөтэй, оролцоотой байхыг эрхэмлэнэ” Томас Жефферсон АНУ-ын 3-р Ерөнхийлөгч

Ил тод, биечлэн оролцох бүрэн бололцоотой байх нь ардчиллын мөн чанар юм.

U

Та иргэн хүний хувьд Монгол улсын Үндсэн хуулийн дараахь заалтын дагуу Улсын төсвийг УИХ-аар хэлэлцэх үед өөрийн тойргоос сонгогдсон гишүүнээрээ дамжуулан саналаа гаргаж болно. УИХ-ын гишүүд иргэн Та бидний оролцоог шууд төлөөлж байгаа гэдгийг үргэлж санаарай.

Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ.

Монгол Улсын Үндсэн хууль. 3 дугаар зүйл.1

Төсөв нь тоогоор илэрхийлэгдсэн улс төрийн хөтөлбөр юм. Иймд төсвийг парламентаар хэлэлцэх үе шат бол хамгийн чухал ач холбогдолтой.

Улсын Их Хурлын хамгийн гол эрхийн нэг нь төсөв хэлэлцэж батлах эрх бөгөөд төсвийн төлөвлөгөөг хууль байдлаар батлан гаргадаг.

Энэ бүхнээс үзэхэд Та өөрийг тань төлөөлөн УИХ-д сууж буй гишүүнтэйгээ улсын төсвийн асуудлаар санал солилцох, мэдээлэл авах, тэр эрхэм гишүүн нийтийн мөнгийг үр ашигтай, оновчтой зарцуулах асуудалд хэрхэн хариуцлагатай ханддаг зэрэг асуудалд анхаарах нь эргээд Та бидний л эрх ашгийн асуудал болох нь ойлгомжтой байгаа биз дээ.

U

Парламентын гишүүнтэй ямар хэлбэрээр харилцаж болох вэ?

- Ø УИХ-ын гишүүнтэй биечлэн уулзах хүсэлт тавих
- Ø Гишүүний бие төлөөлөгчөөр дамжуулан хүсэлтээ тавих
- Ø УИХ-ын гишүүнтэй утсаар ярих
- Ø УИХ-ын гишүүнд захидал бичих
- Ø Өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнд хандан хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил захидал бичих
- Ø УИХ-ын гишүүн тойргынхоо сонгогчидтой уулзах үед төсвийн асуудлаар ярилцах

U

Өөр ямар хэлбэрээр оролцож болох вэ?

- Ø Дээр дурьдсанчлан иргэд төсвийн хөндлөнгийн хяналтыг хийхэд оролцож болно.

Хяналт шалгалтын байгууллага өөрийн эрхлэх хүрээний асуудлаар иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу хяналт шалгалт явуулж болно.

Хяналт шалгалтын байгууллага хяналт шалгалт хийхдээ төрийн бус байгууллага, иргэдийн дэмжлэгийг авч болно.

**“Төрийн хяналт
шалгалтын тухай” хууль
2003 он, 5.13,14**

Энэ талаархи материалыг иргэд СЭЗЯ-ны төрийн захиргаа, удирдлагын газрын мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хандан авч болно. Мөн нээлттэй засаглал веб хуудсаар дамжуулан авч болно. Хаяг: www.open-government.mn

Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

*Монгол Улсын Үндсэн хууль.
16 дугаар зүйл.17*

- Ø Иргэд “Монгол улсын нэгдсэн төсвийн тухай” хуулийн хэрэгжилтийн талаар санал, шүүмжлэл, гомдол гаргаж болно. Энэхүү асуудлаа Санхүү, эдийн засгийн яам, өөрийн тойргоос сонгогдсон гишүүн, холбогдох бусад албан тушаалтан байгууллагад гаргаж болно.

Төрийн байгууллага албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.

*Монгол Улсын Үндсэн
хууль. 16 дугаар зүйл.12*

- Ø Төсвийн үйл явц, хэрэгжилтийн талаархи мэдээллийг хайх, хүлээн авах.

н “Төрийн мэдээлэл” сэтгүүл, Төсвийн гүйцэтгэлийн тайлан, “Санхүү, эдийн засгийн мэдээлэл” сэтгүүл, бусад сонин, сэтгүүлийг үзэхээс гадна, www.open-government.mn, www.mof.gov.mn, Нээлттэй Нийгэм Форумын www.forum.mn гэсэн хаягаар орж төсвийн тухай мэдээлэл авч болно.

Иргэн!¹

Та төрөө сонгодог

Та төрөө санхүүжүүлдэг

Та төрийн хэрэгт шууд оролцох эрхтэй

Та төрөө хянах шүүмжлэх эрхтэй

Үүний тулд Та мэдэх эрхтэй

Мэдэхийн тулд мэдээлэлтэй байх эрхтэй

Иймд Танд Мэдээлэл хүртэх хууль хэрэгтэй!

¹ Мэдэх эрх. Глоб
Интернэйшнл, 2003 он,
3 дахь тал

4.1

Цаашид төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд юу хэрэгтэй байна вэ?

Бусад улс оронд төсвийн үйл явцад иргэд оролцох ямар боломжийг хэрхэн олгосон талаар сонирхож үзье.

Аливаа ардчиллын гол зүрх нь чухамдаа төр засгийн шийдвэрт ард түмний оролцох ухамсартай, идэвхтэй оролцоо байдаг.

Ингэхийн тулд мэдээлэл нээлттэй, ил тод байх явдал зайлшгүй чухал. Ардчилсан улсад чухам энэ боломжийг юун түрүүн иргэддээ олгодог билээ.

Тухайлбал, АНУ-д гүйцэтгэх засаглалын албан тушаалтнууд засаг төрийн асуудал хэлэлцэхээр цугларахдаа ихэнхдээ уулзалтын тухай урьдчилан мэдэгдэж хурал, чуулганы талаар олон нийт нээлттэй хэлбэрээр мэдээлэл авах боломжийг хангадаг байна. Энэ шаардлагыг 1976 онд батлагдсан холбооны “Нар гийх акт”-аар хуульчилснаар аливаа хурал чуулганаас гарч буй шийдвэрийн талаар хүмүүс илүү сайн мэдээлэлтэй байх бололцоо нээгдсэн байна.

1966 онд “Мэдээллийн чөлөөт байдлын тухай” тухай хууль батлагдсанаар америкчууд холбооны зарим байгууллага, яамд, цэргийн байгууллагын тайлангийн хувийг шаардаж үзэх эрхтэй болжээ. Энэ хуулийн ачаар иргэд өмнө нь хаалттай байсан баримт бичигтэй танилцах боломжтой болсон байна.

Түүнээс гадна Засгийн газрын боловсруулсан улсын төсвийн төсөлд бие даасан, хараат бус шинжилгээ хийж, альтернатив төсвийг санал болгох зорилгоор 1986 онд байгуулагдсан “Төсвийн Бодлогын Төв” хэмээх төрийн бус байгууллага нь шинжлэх ухааны байгууллагуудад захиалага өгч төсвийн төсөлд дүн шинжилгээ хийлгэн, илүү оновчтой төсвийн төслийг санал болгодог байна. Ингэснээрээ тэд хамгийн чухал хуулийн нэг болох төсвийн тухай хуульд бие даасан, хараат бус шинжилгээ хийн засгийн газрыг хянах нийгмийн хяналтын үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ нийгмийн тодорхой бүлгийн эрх ашгийг хамгаалсан төрийн бус байгууллагуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй баримт материалаар хангадаг байна.

ХБНГУ-ын Үндсэн хуульд тус улсын санхүүгийн тогтолцоо ба санхүүгийн хуулийн талаархи заалтыг тусгайлан нэг бүлэг болгон оруулж хуульчилсан байна. Мөн ХБНГУ-д Парламентын дэргэд төрийн албан хаагчид хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж буй талаар иргэдээс мэдээлэл авах үүрэг бүхий Комисс ажилладаг ба уг асуудлаар иргэд захиргааны болон үндсэн хуулийн шүүхэд хандаж болно.

Өнөөдөр манайд улсын төсвийн үйл явцад иргэдийн бодит оролцоо хангалтгүй байгаа байдлаас дүгнэлт хийхийн зэрэгцээ бусад орнуудын байдалтай харьцуулан үзэхэд дараахь саналуудыг дэвшүүлэн тавих нь зүйтэй юм. Үүнд:

- Ø Юуны өмнө Үндсэн хуульд санхүүгийн тогтолцоо, улсын нэгдсэн төсвийн харилцааны үндсийг хуульчлах
- Ø Төсвийн харилцааны талаар иргэдэд нийтийг хамарсан сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- Ø Төсвийн болон бусад хуулийн заалтыг иргэдэд ойлгомжтой, боловсронгуй болгох талаар анхаарах
- Ø Төсвийн хөрөнгийг хэрхэн зарцуулж, ямар үр дүнд хүрсэн тухай тайланг олон нийтэд мэдээлэх, хүртээмжтэй болгох
- Ø Төсвийн хөрөнгө нь ард иргэд, аж ахуйн нэгжүүдийн татварын орлогоос бүрддэг тул уг хөрөнгийн зарцуулалтын үр дүн олон нийтэд ил тод байх ёстой
- Ø Төсвийн гүйцэтгэлийн хяналт шалгалт сул учир төсвийн хөрөнгийг үрж шамшигдуулах, зориулалтын бус зүйлд зарцуулах явдал түгээмэл байгаа тул энэхүү хөндлөнгийн хяналтанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зэрэг болно.

Ардчилсан тогтолцооны амин сүнс нь засаг төрийн алба хаагчдын үйл ажиллагааг жирийн иргэд нягтлан хянаж, үнэлж цэгнэж байх чадвар юм. Өөрөөр хэлбэл, төсвийн мөнгөөр санхүүжин, Та бидэнд төрийн үйлчилгээг хүргэх ёстой хүмүүсийг л хэрхэн үүргээ биелүүлж байгааг нь хянадаг, шаарддаг чадвартай байна гэсэн үг шүү дээ.

Үүний тулд улсын төсвийн талаар тодорхой мэдлэгтэй, төсвийг хэрхэн яаж бүрдүүлдэг, яаж зарцуулдаг, гүйцэтгэлийг хэрхэн хянадаг талаар сонирхдог, бодитойгоор оролцдог байх боломжийг гагцхүү ардчилсан, нээлттэй нийгэм Та бидэнд олгож байгаа юм.

